

Энэ явдал 1997 оны 12 сард би Даехан хөрөнгө оруулах сангын судалгааны сургагчаар гадаадад албан томилолтоор явж хөтөчөөр ажиллаж байх үед болсон юм. Тэнд байхад нэгэн хүн надад, "Манмин төв сүмд амийн үг тунхаглагдаж, мөн хүмүүс өвчнөөсөө эдгэрч байгаа" талаар хэлж танилцуулсан юм.

Үүний дараахан би эхнэртэйгээ(И Сун уг СМТ) 5 өдрийн мөргөлдөөн суусан юм. Сургаалийн дараа манай эхнэр Доктор И Жей руг пасторын индэр дээрээс хийсэн өвчний төлөөх залбиралыг аваад төрсний дараах үеийн үрвэслээс эдгэрсэн юм.

Би ч бас 1998 оны 5 сард залбирал аваад архаг нурууны диск өвчнөөсөө төгс эдгэрсэн билээ. Ялангуяа Эхлэл бүлгийн тайлбар, Илчлэлт бүлгийн тайлбар сургаалуудаар дамжуулан олон үл ойлгогдох библийн ниллэлүүдийн тайлбар ба үй олон тэмдэг гайхамшиг, эрх мэдэлт хүчит үйлсүүдийг нүдээрээ харж байгаа болохоор итгэлийн амьдрал минь үнэхээр аз жаргалтай байна.

**Бурханы үг болон залбирлаар эвсэглэлд Тайландад сайн мэдээг тунхаглагч болсон нь**

Тэгж байх үед 2007 онд GCN буюу (Дэлхийн Христийн нэвтрүүлгийн нэгдсэн сүлжээ)-р уг телевизийн нэвтрүүлгийг үзээд их ивээлийг хүртлээ гэх Тайланд итгэгчдийн гэрчлэлийг сонссон юм. Үүнийг сонсоод Тайландад сайн мэдээ тараах хүсэл минь улам оргилж, залбирал ба Бурханы үгээр эвсэглэж эхлэв.

Би 2009 онд манай Манмин төв сүмийн харьяа манмин миссионер бэлтгэх сургалтын төвийн (ММБТ) Тайландад сайн мэдээ аялалд оролцсны дараа тус төвд суралцах болсон юм. Тэр жилийн 11 сарын 9нд Тайландад сайн мэдээ тунхаглагчаар томилогдон илгээгдэж Манмин төв сүмийн Тайланд дахь анхны салбар сүм болох Чэй Пракан Манмин сүмд очиж тусалж байлаа. Тэгмэгцээ би тухайн газрын пасторуудтай танилцаж олон хамтрагчтай болсон юм.

**Манмин Мэдээ сонин, Эрх мэдэлт хүч DVD, болон GCN-ийн**



## “Эрх мэдэлт хүчний нөлөөгөөр сайн мэдээ тараах нь амархан бас аз жаргалтай”

И Жаевон СМТ (Тайланд дахь Чиан Рай Манмин сүм)

**нэвтрүүлгээр дамжуулан сайн мэдээ тараахад голлон ажиллаж.....**

Би цаг л гарвал нотебүүк проектроо аваад бусад сүмүүдэд очин Доктор И Жей руг пасторын “Эрх мэдэлт хүч” DVD г үзүүлж, *Манмин Мэдээ* сониний тайланд хэл дээрх дугааруудыг тайланд сүмүүдэд тараан залбирал хийн өгч байлаа. Үүний үр дүнд болж олон пасторууд номлогч нар над руу утасдаж байлаа. Тэдний нэг нь бол Еден Голд сүмийн пастор Нонг нуктай уулзснаар цаашид улам илүү эрчимтэй ажиллах боломжтой болсон юм.

2010 онд 11р сард И Сон чил пастор (Манмин төв сүмийн дэд пастор) ын удирдан явуулсан эдгэрэл ивээлийн Гар алчуурын цуглаанаар (Үйлс 19:11-12) дамжуулан олон сүмүүд Манмин төв сүмийн салбар сүм болохоор бүртгүүлжээ. Нонг нук пастор ч сүмээ Маннины салбар сүмээр бүртгүүлсэнийхээ дараа GCN ний хиймэл дагуулын антенийг суурилуулан магтаал, сургаал, төрөл бүрийн гэрчлэлийг өдөр бүр үзэж байгаа билээ. Хэдийгээр

Солонгос хэлийг мэдэхгүй ч гэсэн оройн Даниел залбиралын цуглаанд оролцон Ариун Сүнсний тусламжтайгаар их үр жимсийг гаргаж байгаа билээ. Тайландын хойд хэсэгт амьдардаг Росарин эгч дүү нь цусны хордлогын улмаас үхлийн ирмэг дээр байсан ч эдгэрсэн үйл явдал болсон юм. Учир нь Нонг нук пастор нь тэр эгч дүүтэй утсаар холбогдон GCN-р гарч буй Доктор И Жей руг пасторын өвчний төлөө залбирлыг сонсож өгөн залбирал авчирсан учраас тэр эдгэрсэн юм. Тиймээс GCN-ийн нэвтрүүлэг нь зөвхөн Солонгос Англи хэл дээр л цаагаддаг ч гэсэн, хэл яриа ба оройн зай цаг хугацааг үл хамааран гайхамшигт эдгэрлийн үйлсүүд үргэлжлүүлэн гарч байна.

**Чиан Рай Манмин сүмийн байгуулах үйл ажиллагааны дараа ойр орчмын үед орнуудад сайн мэдээ тараах зам нээгдсэн нь**

2011 оны 2 сард И Сон чил пастор урин “Чианг Дао дахь эдгэрэл ивээлийн Гар алчуурын цуглаан”

нээгдсэн юм.

Мөн сүмийн нээлтийн үйл ажиллагааны үеэр радио нэвтрүүлгийн холбоотой хүн санаандгүй орж ирсэн бөгөөд би түүнд Доктор И Жей руг пасторын *Загалмайн Үг* гэдэг номыг бэлэглэсэн юм. Тэр хүн энэ номыг уншсаны дараа “Чиан Рай Манмин сүм нь амийн үг сургаал ба хүчит үйлсүүд дагалдаж байгаа тул Тайланд сүмүүдийн хамгийн үлгэр жишээ сүм болно гэдэгт би баттай итгэж байна,” хэмээн сэтгэл хөдлөн өгүүлж байлаа.

Тэрээр радио нэвтрүүлгээр сургаал номлолыг үнэггүйгээр дамжуулахаар болов. Энэ CRU радио нэвтрүүлгийн төв нь Чиан Райгаас эхлэн Бирм, Лаос руу хүртэл нэвтрүүлгээ цацах өргөн хүрээтэй бөгөөд 7 хоногийн Бамба гариг болон Доктор И Жей руг пасторын “*Загалмайн Үг*” сургаал, Маннины магтаал дуу, өвчтүүдийн төлөө залбирал цаагагдаж байгаа билээ.

**Манмин сайн мэдээ тараах төвийн үйл ажиллагаа**

2011 оны 5 сарт бид Бангкок дахь хүүхдийн хорих төв дээр цуглааныг явуулав. Гил Тэ шиг пасторын удирдан явуулах Пакистан ба Шри Ланка-д болох цуглааныг зохион явуулах номлолын багтай хамт явсан юм.

Хүүхдийн хорих төвд энэхүү цуглаан амжилттай болж тус цуглаанд Хууль зүйн яамны сайд болон Хүүхдийн хорих төвийн дарга болон олон удирдах ажилтнууд суусан юм.

Ялангуяа Хууль зүйн яамны сайд болон бусад эрх мэдэл бүхий хүмүүс Доктор И Жей руг пасторын сайн мэдээ тараах үйлсийн талаар танилцуулах сайхан боломж болсон юм. Доктор И Жей руг пастор нь АНУ-н ерөнхийлөгч Барак Обама-гаас Ерөнхийлөгчийн шагналлыг хүлээн авч талаар видео үзүүлэхэд тэд таатай хүлээн авч байлаа.

Зөвхөн энэ төдийгүй Манмин сайн мэдээ төвийн зөвөөрийн асуудал бүрэн шийдэгдсэн бөгөөд цаашид сайн мэдээ тараах бүх үйл ажиллагаанд хууль зүйн тал дээр бүх талаар хамгаалагдан ажиллах боломжтой боллоо. Халлелуя!

# Манмин Мэдээ

Дугаар 16 2011 оны 10 сарын 2

## Дэлбэрэлт мэт Ариун Сүнсний гайхамшигт үйлс Азид ч гэсэн.....

Дэлхий даяарх 7 тэрбум хүн амын талаас илүү хувь нь амьдардаг бөгөөд дэлхийн дөрвөн том шашин болох Будда, Христ, Хинди, мөн Лалын шашны үсэж бий болсон өлгий нутаг Ази тив.

Энэ Ази тивд ч гэсэн Манмины идэвхитэй үйл ажиллагаа болон номлолоор дамжуулан үр өгөөжөөр дүүрэн, авралын үр жимс арвин их байна. 2011 оны 9 сарын 6-нд Непалын баруун хэсэг Жаба сууринд эдгэрэл, ивээлийн гар алчуурын цуглаан зохион байгуулагдв. Доктор И Жей руг пасторын залбирал хийж өгсөн гар алчуураар залбирал хийж өгөхөд төрөл бүрийн өвчтэй хүмүүс бүрэн эдгэрч Бурханыг алдаршуулан магтлаа. (Үйлс 19:11-12).

9 сарын 19-нөөс эхлэн Японы Киото, Осака, Майзиру Нагояа зэрэг 4 хотуудад гар алчуурын цуглаан нээгдэж, И Хи Сон пастор урилгаар оролцон уг цуглааныг зохион явуулав. Мөн 9-р сарын 8,9нд Энэтхэгт. “Дели Манмин Сайн мэдээ тараах төвийн хамтарсан номлогч нарын семинар” болж өнгөрсөн бөгөөд Энэтхэг ба Бангладешийн 16 мужийн пастор, номлогч нарт Манмины үйл ажиллагаа болон номлолыг танилцуулсан юм.

Мөн түүнчлэн Доктор И Жей руг пасторын сургаалтай холбогдолтой номууд ба олон орны хэл дээр гарсан бөгөөд мөн Ази тивийг бүхэлд нь бүрхсэн ТАЙКОМ 5, НСС6 хиймэл дагуулын антены, Филиппиний кабелийн суваг, Энэтхэгийн “Арулбаку GCN”

телевиз, Пакистаны “Исаак телевиз” гэх зэрэг телевизүүдийн нэвтрүүлгээр болон 19 хэл дээр орчуулагдан гарч буй *Манмин Мэдээ* сонинор дамжуулан ариун сайн мэдээ ба Бурханы эрх мэдэлт хүчийг Ази даяар тунхаглагдаж байна.

Ингэж Азид эрчимтэй сайн мэдээ тараах үйлсийн эхлэлийг Доктор И Жей руг пасторын удирдан явуулсан дөрвөн удаагийн Эдгэрэл ивээлийн нэгдсэн их цуглаанууд суурийг нь тавьжээ. 2000 оны 9-р сард Японы Нагояад болсон Эдгэрэл ивээлийн цуглаан, 2000 оны 10 сард Пакистан дахь Эдгэрэл ивээлийн нэгдсэн их цуглаан, мөн 2001 оны 9 сард Филиппин дэх Эдгэрэл ивээлийн нэгдсэн их цуглаан тус тус нээгдсэн билээ.

Ялангуяа 2002 оны 10-р сард

Энэтхэгийн Ченнай хотын Марина гэх далайн эрэг дээр зохион явагдсан Эдгэрэл ивээлийн нэгдсэн их цуглаанд 3 сая гаруй хүн оролцсон агуу их чуулган болсон юм. Энэтхэгийн засгийн газрын нэг бүлэг Тамил Наду бүлгийнхнээс гадны шашин сурталчлахыг хориглосон хуулийг гаргаж, энэ нэгдсэн их цуглааныг зогсоохыг оролдсон боловч уг цуглаанд оролцогчдын дундаас олон хараагүй хүн хараа орж, дүлий хүн сонголтой болж, олон хүмүүс таяг, тэргэнцэрээ хаяаад алхаж тэр ч бүү хэл ДОХ өвчин ч гэсэн эдгэрсэн эрх мэдэлт хүчит үйлсүүд маш ихээр гарсан бөгөөд маш олон хүмүүс Бурханыг алдаршуулан магтаж, Эзэнийг хүлээн авсан юм.



▲ Монгол дахь Гар алчуурын цуглаан



▲ Доктор И Жей руг пасторын 2002 оны Энэтхэгийн Эдгэрэл ивээлийн нэгдсэн их цуглаан



▲ Тайланд дахь Гар алчуурын цуглаан



▲ Шри Ланка дахь Пастор номлогч нарын семинар



▲ Казахстан дахь Гар алчуурын цуглаан



▲ Непал, Бутанд болсон Гар алчуурын цуглаан



▲ Доктор И Жей руг пасторын Филиппиний Эдгэрэл ивээлийн нэгдсэн их цуглаан



▲ Малай дахь Гар алчуурын цуглаан



▲ Вьетнам дахь Пастор номлогч нарын семинар



▲ Доктор И Жаевон пасторын 2000 оны Пакистан дахь Эдгэрэл ивээлийн нэгдсэн их цуглаан



▲ Доктор И Жей руг пасторын Филиппиний Эдгэрэл ивээлийн нэгдсэн их цуглаан



▲ Жагд дахь Сүмийн удирдагчдын семинар

### Авто ослоос болж ухаан алдсан хүнд эрх мэдэлт алчуураар залбирахад сэргэлээ.



Бирид автомашины ослолд орон ухаан алдсан Лотчана Пүн сүх эгч дүү нь хилийн нөгөө талд Тайландын Чиан Рай хотын эмнэлэгт хүргэгдэв. Энэ тухай И Жейвон СМТ-д утсаар мэдэгдэхэд тэрээр охин дээр очиход 10 хоногын турш ухаангүй байсныг нь олж мэдлээ. Тэрээр эрх хүчит гар алчуураар түүнд залбирал хийж өгмөгц тэр охин ухаан орж түүний гараас барьсан бөгөөд одоо тэр охин юм ярих ч боломжтой болсон юм. (Үйлс 19:11-12).

### Доктор И Жей руг пасторын Загалмайн Үг номоор дамжуулан гэр бүлээрээ Эзэнийг хүлээн авлаа



Амиа хорлох гэж хүртэл оролдож байсан хэцүү амьдралаар амьдарч байхдаа “Загалмайн Үг” номыг уншиж өөрчлөгдсөн Чиан Рай Манмин сүмийн итгэгч Вирая Бирита итгэгч. Хиймэл шүтээн маш айтар шүтэж байсан түүний нөхөр Эзэнийг хүлээн авч 1,500 хиймэл шүтлэгийг нэг мөсөн хаяж түүнээс хойш тэд ерөөл ивээлээр дүүрэн байна.

### Мөргөлийн цагийн хуваарь

Мөргөл	Цаг
Хүндэтгэлийн их мөргөл	Ням гариг 10: 30
Үдээс хойшхи мөргөл	Ням гариг 11: 30
3 дахь өдрийн мөргөл	Лхагва гариг 18: 00
5 дахь өдрийн мөргөл	Баасан гариг 21: 30
Хүүхдийн цуглаан	Ням гариг 09: 00
Сурагчдын цуглаан	Бямба гариг 15: 00
Залуучуудын цуглаан	Мягмар гариг 17: 00

### Pgldnjlsy wgsy heggj,

Ангилал	Цаг	Удирдагч
Үүрийн залбирал	05:00-06:00	Г.Анхбаяр СМТ Чуулганы хариуцагч
Өглөөний залбирал	Даваа-Баасан 09:30-10:30	Г.Анхбаяр СМТ Чуулганы хариуцагч
Оройн Даниел залбирал	Өдөр бүр 18:00- 19:30	Г.Анхбаяр СМТ Чуулганы хариуцагч

Манай хаяг:

Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 12-р хороо, Хангайн 3-57тоот

Улаанбаатар Ариун баярт мэдээ чуулган

Чуулганы утас: 976-11-351437

Чуулганы хариуцсан төлөөлөгч:

Г. Анхбаяр СМТ 976-91173712

976-91615337

Е- шуудан : power3712@gmail.com



“Загалмайн Сайн Мэдээ” Цувралууд (14)

# Есүсийн хувцсанд агуулагдсан Бурханы төлөвлөгөө

“Цэргүүд Есүсийг цовдлоод, гадуур хувцсыг нь авч дөрвөн хэсэг болгож хувь хувиа хүртжээ.... Тэд хоорондоо, “Үүнийг урагхуй. Харин хэнийх болохыг шийдэхийн тулд үүний төлөө шодоцгооё”, гэв. Энэ нь “Тэд гадуур хувцсыг минь хуваан авч, Миний хувцасны төлөө шодох болно” [гэсэн] судар биелэгдэхийн тулд ажээ. (Иоанн 19:23-24).

Есүс нь гэм нүгэлтэн болох бүх хүн төрөлхтөнийг аврахын тулд энэ дэлхийд ирж, маш олон хүнд зовлон хавчлагыг туулан,загалмайд цовдлогдон нас бараад, дахин амилан дээш одсон юм. Үүний улмаас хэн ч гэсэн Аврагч Эзэн болсон Есүст итгэвэл Бурханы хүүхэд болох эрх мэдлийг хүлээн авах болно. Тиймд Есүсийн амсан зовлон ба түүнд агуулагдах утга учруудыг нарийн тодорхой мэдвэл Бурханы хайрыг улам гүн ухаарч ойлгон халуун итгэлийн амьдралаар амьдрах болдог. Тэгвэл Есүс яагаад олон хүмүүсийн өмнө нүгчлэгдсэн доромжлогдсны утга учир ба мөн Есүсийн гадуур болон дотуур хувцсанд агуулагдсан Бурханы төлөвлөгөө нь чухам юу юм бол?



Доктор И Жаерок Тэргүүн Пастор

## 1. Гэм нүгэлтнүүдийн ичгүүрт байлаас нь аврахын тулд Өөрөө нүгчлэгдэн ичгүүрийг амсан Есүс

Есүс цовдлогдох загалмайгаа Өөрөө үүрээд Голготын толгод хүртэл нуруундаа үүрч явжээ. Эцэст нь Түүнийг толгодын оройд хүрч ирмэгц цэргүүд Есүсийн гадуур болон дотуур хувцсыг бүгдийг нь булаан авч нүгчлэгдэж, загалмайд цовдлогдон юм. Хамгийн Дээд Агуу Бурханы цорын ганц хүү Есүс өчүүхэн бөгөөд сул дорой бүтээл болох хүмүүсийн өмнө нүв нүгчэн байх ичгүүрийг амсан билээ.

Тийм бол Есүс яагаад энэхүү ичгүүрт байдлыг амсах ёстой байсны учир юу вэ? Тэр бол бидний амсах ёстой ичгүүрт байдлаас биднээс чөлөөлж, бидний өмнөөс ичгүүрт байдлыг амсаж туулсан билээ. Гэм нүгчлэгдэнүүдийн мэдээжийн авах ёстой байсан эмзэгл зэвүүцэл ба ичгүүрийг огтхон ч нүгчлэгүй Есүс бидний өмнөөс амсан юм.

Хамгийн бохир бузар мөн гутамшигтай зүйл бол гэм нүгэл юм. Тиймд олон хүмүүс гэм нүглийн дотор амьдарч байгаа тул тэд гэм нүглийн тухай маш хайхрамжгүй хандаж ба гэрэл гэрэлтэхэд харанхуйд байх бохир бузар зүйлс ил гардагийн адил Гэрэл болсон Бурханы Үг бидний зүрх сэтгэлийг нь гэрэлтүүлэхэд өөрсдийнх нь дотор бүх ичгүүрт гэм нүгдүүд нь илчлэгдэх болно. Энэ дэлхийн бохир бузар байдал болон гэм нүгдэд хугтагдан амьдарч байгаа хүмүүс эцэстээ Бурханы шүүлтийн өмнө зогсох үед өөрсдийнх нь хорон муу зүрх сэтгэл ба гутамшигт үйлс бүгдээрээ нэг нэгдгийг илчлэгдэх тул толгойгоо өргөж ч чадахгүй шүүгдэх юм.

Тийм бол Есүс биднийг гэм нүглээс чөлөөлж, бидний авах ёстой байсан ичгүүр болон гутамшигт өмнөөс минь туулсан, бөгөөд үүнд итгэдэг бид гэм нүгэлтийн амсах ичгүүрт байдлаас ангижрах боломжтой болсон юм. Тиймээс бид чин сэтгэлээрээ Эзэний хайранд талархан маш хурдан ариун байдлыг төгс биелүүлснээрээ өчүүхэн ч ичих зүйлгүй Эзэнийг угтан авах болно.

## 2. Цэргүүд Есүсийн гадуур хувцасыг хувааж, дотуур хувцсыг нь хуваалгүй шодож авсны утга учир

Цэргүүд Есүсийн Түүний гадуур болон дотуур хувцсыг нь тайлж аваад, гадуур хувцсыг нь дөрвөн хэсэг хувааж цэргүүд өөрсдийн хувиа хүртжээ. Харин дотуур хувцас нь дээрээ нь битүү нэхсэн, мөн

ямарч оёдолгүй байсан бөгөөд үүнийг шодож нэг нь авахаар болжээ. (Иоанн 19:23-24). Тиймээс “Тэд миний гадуур хувцсыг хоорондоо хувааж, Миний дотуур хувцасны төлөө шоддог.” (Дуулаал 22:18) гэсэн зөгнөл биелсэн юм.

Энэ мэт Есүсийн хувцасны тухай библид маш тодорхой тэмдэглэгдсэн байдаг бөгөөд Түүний хувцас нь Израйлийн түүхийг бэлгэддэг юм. Эхлээд Бурханы Хүү ба Израйлийн хаан болох Есүсийн гадуур хувцас нь сүнс зүгийн утгаар бол Израйль улс үндэстэн бэлэгдэж байна. Тэгвэл Түүний гадуур хувцас нь дөрвөн хэсэг болон хуваагдсан болохоор, энэ хувцасны хэлбэр нь алга болж, хувцасных нь өөдөс хэлтэрхий төдий л үлдсэн байлаа. Энэ нь Израйль улс мөхөж, устаж Есүсийн гадуур хувцаснаас зөвхөн давууны өөдөс хэлтэрхий үлдсэн шиг зөвхөн, “Израйль” гэсэн нэр үлдэн гэдгийг гэсэн утгатай юм.

Ромын цэргүүд Есүсийн гадуур хувцасыг хувааж авсан гэдэг нь Израйльчууд Ромд эзлэгдэн мөхөж устагдахыг зөгнөж байгаа бөгөөд дөрвөн хэсэг болон хуваасан гэдэг нь Израйлийн ард түмэн дөрвөн зүг рүү өөрөөр хэлбэл дэлхий даяар хойд, өмнө, зүүн, баруун зүг рүү дүрвэн тархах болно гэдгийг зөгнөж байгаа билээ. Лук 19:43-44 дээр үзвэл Есүс Иерусалимын тухай зөгнөсөн тухай гардаг. “Дайснууд чинь чиний эсрэг бэхлэлт босгон чамайг бүсэлж, тал талаас чинь бүчих өдрүүд ирэх үед чамайг болон чиний дотор хүүхдүүдийг чинь газартай тэгшлэх болно. Тэд чиний дотор чулуут чулуун дээр нь орхихийг. Учир нь чам дээр Бурханы ирсэн цагийг чин мэдээгүй юм гэв.”

Энэ зөгнөлийн дагуу М.Э. 70 онд Ромын жанжин Титус Иерусалимд нэвтрэн орж ирэн устаж сүйтгэсэнээр энэ зөгнөл биелсэн юм. “Тэд чулууны дээр чулууг ч үлдээхгүй.” гэж Есүсийн айлдсанчлан Иерусалимыг бүгдийг нураан сүйтгэсэн юм. Мөн хотын бүслэлтийн үед 1 сая гаруй Иудейчүүд алагдсан бөгөөд үүнээс амьд үлдсэн хүмүүс 4 зүг рүү дүрвэн тархаж, тэд харь үндэстнүүдийн дунд амьдарч байхдаа маш олон хавчлага дарамтанд амьдарч байсан юм.

Иудейчүүдийн амсаж туулсан хамгийн аймшигтай хавчлага харгис хэрэгчийн зовлон бол Дэлхийн хоёрдугаар Дайны үед дэхь Нацист дэглэмийн үед 6 сая гаруй хүн зөвхөн еврей хүн, иудейчүүд

гэсэн шалтгаанаар үй олноороо хомроглон устгагдсан бөгөөд ялангуяа нүгчлэгээрээ алагдсан юм. Энэ мэт үй олон хүн алагдсан нь Иудейчүүд өөрсдийнх нь хаанаар ирсэн Есүсийг харсан тул тэдний хойч үе үр удамд оногдох караалуудын нэгэн энэ үйл явдал байсан юм.

Иудейчүүд Есүсийг загалмайд цовдлохыг хүсэхэд, тухайн үеийн захирагч Понти Пилат Есүсийг алуулах ямар ч гэмгүй болохыг мэдээд цаазаар авах ялыг өгөхгүй байхыг хичээсэн билээ. Тэгсэн ч гэсэн Иудейчүүд үргэлжлүүлэн цаазаар авахыг шаардаж байхад Понти Пилат тэдэнд хандан “Би энэ Хүний цусанд буруугүй. Өөрсдөө мэдтгэй,” гэж хэлжээ (Матай 27:24). Тэгэхэд Иудейчүүд үргэлжлүүлэн “Түүний цус бидний болон бидний үр хүүхдүүдийн дээр байг!” хэмээн хашгирагдаж (Матай 27:25), Есүсийг загалмайд цовдлох гэж эцсээ хүртэл зүтгэсний үр дүнд тэд санасандаа хүрэн Есүсийг загалмайд цовдогдож, эцэст нь тэд хэлснийхээ дагуу Есүс цус тэдний дээр болон тэдний үр удмын дээр бууж аймшигтайгаар мөхөхөд хүрч тэдний үр удам ч гэсэн маш хунд хавчлага зовлон дотор амьдрах болсон нь Есүсийн гадуур хувцасыг 4 хэсэг хуваасан үйл явдалтай холбоотой бөгөөд үүнд ч гэсэн давхар илэрхийлэгдсэн юм.

Дараа нь Есүсийн дотуур хувцас “оёдолгүй” байв гэдэг нь давуугаар нь зүү утсаар оёогүй бөгөөд дээрээс авахуулаад битүү нэхсэн хувцас байсан юм. Эндээс “дотуур хувцас” нь хүний зүрх сэтгэл гэсэн утгатай юм.Тиймээс Израйлийн хаан Есүсийн дотуур хувцас нь Израйлийн хойч үеийнхний зүрх сэтгэл бөгөөд тэдний Бурханд итгэх итгэлийг илэрхийлж байна.

Бурханы ард түмэн Израйлийн үндэс суурь нь Иаков юм. Бурхан Иаковын нэрийг “Израйль” хэмээн өөрчлөөд түүнээс гарсан арван хоёр хүүгээр дамжуулан Израйлийн арван хоёр овогийг бий болгожээ. Израйлийн ард түмэн удаан хугацааны турш бусад үндэстнүүдтэй гэрлэж, холилдолгүйгээр дан ганц ураг үндэстэн болж зөвхөн Бурханд үйлчилсээр л ирсэн юм.

Тэгтэл Соломон хааны хүү Рехобоамын үед, Израйль хуваагдаж, хойд Израйль ба өмнөд Иуда гэсэн 2 хэсэг хуваагдсан юм.Үүнээс хойш хойд Израйль нь харь үндэстнүүдтэй гэрлэн, дан ганц ураг үндэстэн гэсэн хэлбэрээ алдсан юм.

Харин Өмнөд Иуда нь жинхэнэ израйль үндэстний хойч үе болохынхоо хувьд харь үндэстнүүдтэй холилдолгүй хэвээрээ үлдсэн юм. Тийм учраас одоог хүртэл Израйлийн хойч үеийн үр удмыг “Иудей хүн” буюу Иудейчүүд гэж нэрлэгддэг билээ.

Есүсийн дотуур хувцас нь дээрээсээ битүү нэхэгдсэн шиг Иудейчүүд нь тэдний өвөг дээдэс болох Иаковаас авахуулан үргэлжлүүлэн ганц угсаа залгамжилсаар өдий хүрсэн юм. Тийм учраас Ромын цэргүүд Есүсийн дотуур хувцсыг ураагүй бөгөөд энэ нь сүнс зүгээр бол Иудейчүүдийн Бурхан руу хандсан чин зүрх сэтгэлийг ямар нэгэн хүн хувааж юм уу устгаж чадахгүй гэсэн утгатай юм.

Ром нь Израйльчуудын итгэл бишрэлийг нь хүртэл устгахыг хичээсэн боловч эцэстээ тэгж чадаагүй юм. Иерусалим мөхсөний тал тал тийшээ дүрвэн бутарсан Иудейчүүд нь түүн шигээ урт удаан хугацааны турш зовлонг эдэлж байсан ч өөрсдийн итгэл найдвараа алдалгүй байж эцэст нь 1948 оны 5 сарын 14нд өвөг дээдсийнхээ нутаг руу буцан иржээж тусгаар тогтнолоо зарласан юм.

Энэ нь Езекиел 38:8-12 дээр бичигдсэн зөгнөл тэр чигээрээ биелэгдсэн юм. Энд, “Олон хоногын дараа та нар дуудагдах болно.” гэж айлдсан байдаг ба дэлхийн өнөөг булан бүр газар газраас Израйлийн ард түмнүүд Израйль нутагтаа эргэн ирж улс нь дахин сэргэх болохыг зөгнөсөн болохыг харж болно. Дэлхий дээр ямар улс үндэстэн үүн шиг аймшигтай хавчлага ба зовлонг туулангаа өөрсдийн удам угсаа ба итгэл бишрэлээ сахиж, мөн мөхөн тарж бутарсныхаа 2000 жилийн дараа дахин сэргэсэн бэ?

Израйлийн өвөг дээдэс Иаковаас залгамжлагдан ирсэн ард түмний чин зүрх сэтгэл ба итгэл бишрэл нь тэр хэмжээний бат бөх байсныг дээрээс нь битүү нэхсэн Есүсийн дотуур хувцас нарийн тодорхой илэрхийлж өгчээ.

Хайрт итгэгч Ах эгч, дүү нар аа,

Энэ мэт Иерусалимын эзлэгдэлт ба Иудейчүүдийн зовлон Израйлийн мөхөл ба дахин сэргэлт бүгдээрээ библид тэмдэглэгдсэнчлэн бүгд биелсэн билээ. Библи дээр арай биелэгдээгүй зүйл нь цаашид биелэгдэх бөгөөд түүн дотроос биелэгдэхэд маш ойрхон зүйл нь Эзэн биднийг авахаар дахин энэ дэлхийд ирэх явдал юм.

Тиймээс цаг мөч болгон сэрүүн байж, залбирал хийн Эзэний сүйт бүстгийн бэлтгэлээ сайн хийж, дахин ирэх Эзэнийг багтайгаар угтан авахад бэлэн байхыг Их Эзэний нэрээр хүсэн сөрөж байна!

Mongolian

**Манмин Мэдээ**  
Published by Манмин Тов Сүм

235-3 Гуро-Здонг, Гуро-гу, Севл,  
152-848 Солонгос Улс  
Утас: 82-2-818-7047 • Факс: 82-2-2818-7048  
http://www.manmin.org/english  
e-mail: manminministry@hotmail.com  
Нийтлүүлэгч: Жаерок Лее  
Редактор: Геумсун Вин



Сургаалын цаг



Ариун Сүмнийг байхал дүүрэн залбирлын цуглаан



Спортын тэмцээн



Галын наадам



Мүан амтат усны хүрээлэн



Сонотой хамт

# “Манмин зуны цуглаан мартагдашгүй, сэтгэл хөдлөм агшинаар дүүрэн байлаа”

Манмины эрэгтэй эмэгтэй итгэгчдийн зуны цуглаанд АНУ, Канад, Бельги, Казахстан, Израйль, Сингапур, Япон, Хятад, Филиппини зэрэг гадаадын 29 улс орнуудаас 330 пастор номлогч нар болон итгэгчид оролцон дэлхий хэмжээний баяр наадмын жинхэнэ үлгэр жишээг үзүүлсэн юм. Сургаал үг ба залбирал, тэмдэг, мөн гайхамшгуудыг хүсэн хүлээсэн оролцогчдын ивээл дүүрэн гэрчлэлийг үзэцгээе!

## Эрх мэдэлт хүч ба тэмдэг гайхамшгуудаар Европыг сэрээгдэхийг хүсэн.....

Доктор Лилиана Ван Хүллен (Библийн судлалын Доктор, AEGA Европын нэгдсэн холбооны дарга)

Би АНУ-гийн Люсианад байдаг AEGA (Ариун сайн мэдээний нэгдсэн хороо) – ны гишүүн бөгөөд Манмин төв сүмтэй харилцаа тогтоохын тулд илгээгдсэн билээ.

Би Солонгост анх удаа айлчилж байгаа бөгөөд маш олон зүйлийг мэдэж байна. Манмины эрэгтэй эмэгтэй итгэгчдийн зуны цуглаанд оролцсоороо илүү гүн гүнзгий Эзэний дотор байгаагаа тодорхой мэдэрсэн юм.

Би бас соно над дээр суухыг үзэж, шөнийн тэнгэр дэх одны хөдөлгөөнийг харлаа. Мүан Манмин сүмийн дээгүүр харагдах солонгосыг харж тэр солонгон дотроос Ариун

Сүнсний гал буун ирж байхыг онгодоор харсан юм. Би өнөөг олон тэмдэг ба гайхамшгуудын тухай сонссон боловч эдгээрийг анх удаа биеэрээ мэдэрч, нүдээрээ харж байна. Мөн Бурхан амьд болохоор энэхүү хүчтэй үйлсийг үзүүлсэнд итгэсэн юм. Эдгээрээр дамжуулан тэмдэг гайхамшиг хайгаад ч олохгүй Европыг сэрээвэл сайн юмсан гэж бодож байна.

Би өнгөрсөн жилийн 10 сард Доктор И Жей руг пасторын Естонийн Таллинд болсон нэгдсэн их цуглаанд оролцон түүний сургаалыг сонссон юм. Зүрх сэтгэл дэх хорон муу хаяж, алдагдсан Бурханы дүү төрхийг буцаан авах нь ариун

сайн мэдээний сургаалын гол цөм болохыг би ухаарсан юм. Мөн энэ зуны цуглаанаар дамжуулан оролцогчдын зүрх сэтгэл Бурханы хүч болон Эзэний хайраар өөрчлөгдөхийг харсан юм. Солонгост байхдаа авсан ивээл ба ухаарсан зүйлүүдээ цаашид Европ хүмүүсийн төлөө ажиллахад их тус нэмэр болох болно. Европчууд шинэчлэгдэж ивэрч өөрчлөгдөхийн тулд Би Манминтай улам их нэгдэхийг хүсч байна.



АНУ-гаас Николай Палников итгэгч “Миний сонссончлон энэ удаагын зуны цуглаан их онцгой бөгөөд янз бүрийн үйл ажиллагаатай байлаа. Би Америкд эсвэл Орос ч иймэрхүү зуны цуглааныг ерөөсөө үзээгүй билээ. Сургаалын цагууд болон маш өндөр түвшинд бэлтгэгдсэн магтаал дууны багуудын тоглолт үнэхээр гайхалтай байлаа. Энэ хугацаанд би интернетээр Манмин төв сүмийн мөргөлд оролцож, Бурханы хүчтэй үйлсүүдийг хардаг байсан ба энд байхад миний хурууны үзүүр ба толгой дээр соно суухыг харахад сэтгэл их хөдөлж баяртай байлаа” гэж өгүүллээ.

Фернандо Борбон, Коста Рикагийн Өмнө Солонгост суугаа бүрэн эрхт элчин сайд одны хөдөлгөөнийг харж ихэд догдлон баярлаж тэрээр өгүүлдэхээ “Одны хөдөлгөөнөөр дамжуулан Бурхан бидэнтэй хамт байгаа мэдэрч байна” хэмээн сэтгэл хөдлөн хэлж байлаа.

Спортын тэмцээнд Шилдэг Тамирчин гэх шагналыг авсан Бельги улсаас ирсэн Женнифер эгч дүү хэлэхдээ, “Би ийм шагналыг авна гэж ерөөсөө төсөөлөөгүй бөгөөд маш их гайхсан. Би Бурханы тусламжаар тэмцээнд хожсон гэж бодож байна. Би Европд олон Христэч зуны цуглаанд оролцож байсан боловч Манмины зуны цуглаан нь үнэхээр сэтгэл хөдлөм гайхалтай бөгөөд Бурхан хамт байгааг мэдэрсэн юм. Энэ удаагын зуны цуглаанаас би их ивээл ба ерөөлийг хүртлээ.”

Алекс Смотров Оросын Санкт Петербург Манмин сүмийн харьяа Библийн сургуулийн эрхлэгч хэлэхдээ, “Соно нисч ирээд над дээр суусан нь маш гайхамшигтай байлаа. Мөн зуны цуглааны эхний өдөр И Буг ним залбирлын ахлагчын удирдан явуулсан залбирлын цуглаан үнэхээр сайхан байсан. Тэр надад залбирал хийж өгөхөд нулимс урсаж хэлээд би үүнийг зогсоож чадахгүй байлаа.” Түүний эхнэр Екатерина Смотрова хадагтай хэлэхдээ, “Ийм олон итгэгчид нэг зүрх сэтгэлтэйгээр маш зохион байгуулалт сайтай зуны цуглааны бүх үйл ажилгаанууд явагдаж байгааг хараад их ивээл хүртлээ.” гэж өгүүллэн юм.

Шри Ланка дахь Сант Лук сүмийн Патрик Рожер Лавренс, “Ийм олон хүн оролцож байгаа нь маш гайхамшигтай байна. Яг тэнгэрийн оронд байгаа юм шиг байна” гэж хэллээ.

Израйль Иерусалимаас ирсэн Мариа Горен эгч дүү хэлэхдээ “Маш олон итгэгчид нэг зүрх сэтгэлээр Бурханыг магтаж байгааг хараад би маш их ивээл авлаа. Ялангуяа сургаалиас их ивээл авсан ба амьдралдаа хэрэгжүүлэхийг хүсч байна.”

Израйль Ашдод дахь Манмин Сүм Пастор Олег Ершов, хэлэхдээ, “Би цэлмэг сэрүүхэн цаг агаараар дамжуулан ивээл авсан билээ. Бурхан бүх үйл ажиллагааны үеэр бороо орохыг зогсоож, хэрэгтэй үед нарыг үүдээр халхалж өгч байгааг харсан юм. Үнэнийг хэлэхэд спортын тэмцээн болох газар руу явахаар хөдлөхөд бороо орж байсан тул би санаа зовж байсан ба “Өнөөдрийн спортын тэмцээн яах бол?” гэж бодож байлаа. Гэвч миний эргэн тойронд хамт байсан итгэгчид “спортын тэмцээн болох газар очвол бороо орохгүй” баттайгаар хэлцгээж байсан юм. Үнэхээр спортын тэмцээн болох газар очтол тэнгэр цэлмэг болснийг хараад их ивээл хүртсэн юм.”

Кени улсаас ирсэн Мүнге, Стелла, Дебора эгч дүүс хэлэхдээ, “И Хи сон пасторын удирдсан “Галын наадам” үнэхээр гоё байлаа. Үүгээр дамжуулан Бурханы агуу хайрыг мэдэрсэн юм. Мөн Мүан амтат усны хүрээлэнд зочилсон нь мөн соно, одны хөдөлгөөнүүд, үзэсгэлэнтэй гэрлүүдийг харсандаа их баяртай байна.”